



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/52

Улаанбаатар хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.6 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 12 дахь хэсгийн 12.13 дахь заалт, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15<sup>1</sup> дүгээр зүйлийн 15<sup>1</sup>.3 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/219 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох эрхийг дүүргийн Засаг дарга нарт шилжүүлсэнтэй холбогдуулан дүүргийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлаар дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгоход мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, худалдаа, үйлчилгээтэй холбоотой асуудлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулан, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Ажлын хэсэг (Б.Болормаа)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД


Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 152 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт



СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, МАГАДЛАН ШАЛГАХ ДҮГНЭЛТ ГАРГАХ  
ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч
Гишүүн:	Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хяналтын хэлтсийн Хүнсний чанар, стандартын хяналтын улсын ахлах байцаагч (зөвшилцсөнөөр) Хотын стандарт, хяналтын газрын Худалдаа үйлчилгээний стандартын хэлтсийн Худалдаа, Үйлчилгээний байгууллагын стандарт хариуцсан мэргэжилтэн (зөвшилцсөнөөр) Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга Дүүргийн Цагдаагийн хэлтсийн дарга Дүүргийн Татварын хэлтсийн дарга Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн орлогч, гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, ахлах байцаагч 1 дүгээр хорооны Засаг дарга 2 дугаар хорооны Засаг дарга
Нарийн бичгийн дарга:	Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн Худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл хариуцсан ахлах мэргэжилтэн

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны 03 дугаар сарын 03 -ны өдрийн 03 дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт



СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХТОЙ ХОЛБООТОЙ АСУУДЛААР ДҮГНЭЛТ  
ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Дүүргийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгээс Зөвшөөрлийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг баримтлан тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлдүүлэх, сэргээх, хүчингүй болгох асуудлаар дүгнэлт гаргах, тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд хүргүүлэхэд энэхүү удирдамжийг баримтална.

Хоёр. Ажлын хэсгийн ажиллах зарчим

- 1.1 Ажлын хэсэг дараах асуудлыг хэлэлцэж дүгнэлт гаргана
  - 2.1.1. Дүүргийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох
  - 2.1.2. Тусгай зөвшөөрлийн хаягийн өөрчлөлт, аж ахуйн нэгжийн нэр солих
  - 2.1.3. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх
  - 2.1.4. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах
  - 2.1.5. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох
- 2.2. Ажлын хэсэг Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15<sup>1</sup> дугаар зүйлийн 15<sup>1</sup>.3-т заасны дагуу баримт бичгийн бүрдэл шалгах болон магадлан шалгах ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу ажлын 10 өдрийн дотор шийдвэрлэнэ.
- 2.3. Магадлан шалгах ажиллагаанд төрийн болон мэргэжлийн байгууллагаас дүгнэлт, тодорхойлолт гаргуулах шаардлагатай бол энэ удирдамжийн 2.2-т заасан хугацааг нэг удаа ажлын 5 өдрөөр сунгаж болно.
- 2.4. Ажлын хэсэг магадлан шалгах хугацааг дууссанаас хойш ажлын 3 өдөрт багтаан хуралдах бөгөөд хурлыг танхимаар болон цахимаар зохион байгуулж, зөвшөөрөл олгох эсэх шийдвэр гаргана.
- 2.5. Ажлын хэсгийн гишүүдийн гуравны хоёр нь оролцсоноор хурлыг хүчинтэйд тооцно. Хуралд ажлын хэсгийн нарийн бичгийн дарга саналын эрхгүй оролцох бөгөөд ажлын хэсгийн хурлын бэлтгэл ажил, зохион байгуулалтыг хариуцан ажиллана.

## 2.6. Ажлын хэсгийн хурлыг дарга удирдана.

Гурав. Ажлын хэсгийн хурлын бэлтгэл ажлыг хангах, магадлан шалгах, зохион байгуулах

- 3.1.1. Нийслэлийн мэдээ мэдээллийн Ulaanbaatar.mn цахим хуудасны "Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем"-ээр Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хүсэлт ирүүлсэн хуулийн этгээдийн баримт бичгийн бүрдлийг магадлан шалгасны дараа жагсаалтыг гарган, танилцуулгыг powerpoint программ дээр бэлтгэж, хурал болохоос өмнө бэлтгэл ажлыг хангана.
- 3.1.2. Холбогдох байгууллага, хуулийн этгээдээс тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохоор ирүүлсэн саналыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хурлаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөнд тусгана.
- 3.1.3. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн хүсэлтийг магадлан шалгаж, дүүргийн Засаг даргын дэргэдэх Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөлд хүргүүлнэ.
- 3.1.4. Тус магадлан шалгасан хуулийн этгээдийн жагсаалтын дагуу дүүргийн Засаг даргын дэргэдэх Худалдаа, үйлчилгээг Зохицуулах зөвлөл нь үйл ажиллагаа эрхлэх ажлын байр, объект дээр биечлэн очиж зургаар баталгуужуулж, тэмдэглэл хөтлөх бөгөөд холбогдох мэдээ, мэдээлэл, тайланг хурал зохион байгуулагдахаас өмнө нарийн бичгийн даргад хүлээлгэж өгнө.
- 3.1.5. Тайлан, мэдээг хуулийн этгээдийн нийслэлийн мэдээ, мэдээллийн Ulaanbaatar.mn цахим хуудасны "Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем"-ээр согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн ирүүлсэн хүсэлттэй тулгаж, хянан баталгаажуулна.
- 3.1.6. Ажлын хэсгийн гишүүд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл хүсэгч энэ журмын 3.1.2-т заасан жагсаалтад дурдсан хуулийн этгээдийн жагсаалт, мэдээлэлтэй танилцан баримт бичгийн бүрдлийг хянан баталгаажуулж зөвшөөрөл олгох эсэх дүгнэлтэд санал өгнө.
- 3.1.7. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн магадлан шалгагдсан мэдээллийг жагсаалтын дагуу хуралд танилцуулж, ажлын хэсгийн гишүүн тус бүрээс санал авах хуудсыг бөглүүлэн, хурлын тэмдэглэлийн хавсралтад тусгана.
- 3.1.8. Ажлын хэсгийн гишүүд нь санал авах хуудсанд тусгай зөвшөөрөл олгох саналыг "+" тэмдгээр, татгалзсан болон хугацаат үүрэг, даалгавар өгөх үндэслэлийг холбогдох хууль тогтоомж, норм дүрэм, стандартыг тодорхой тусгаж, гарын үсэг зурж баталгаажуулна.
- 3.1.9. Хуралд оролцсон ажлын хэсгийн гишүүд хурлын тэмдэглэлд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд оролцсон гишүүдийн гуравны хоёрын саналаар дэмжсэн, эсхүл татгалзсан тухай дүгнэлт гаргана. Дүгнэлтэд ажлын хэсгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
- 3.2 Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хурлын тэмдэглэл, дүгнэлтийг Засаг даргад хүргүүлж, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлд заасан хугацаанд шийдвэр гаргуулна.